



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 15 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдааныг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар /2025-07-08/ Сонгон шалгаруулалт зарлах тухай (Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт); Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай /Хорооны 2025 оны 115 тоот тогтоолыг хэрэгжүүлэх/ (Үүнд: Нийт 5 сонгон шалгаруулалтыг зарлах, холбогдох СШББ-ийн төслийн хэлэлцэн батлах асуудал, 1.Монгол Улсад арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох; 2.Улаанбаатар хотод арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох; 3.Увс аймагт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох; 4.Дундговь, Говьсүмбэр аймагт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох; 5.Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2019 оны 43 тоот тогтоол) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 14 (Тогтоол №150-163, 2025-07-08) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Харилцаа холбооны зохицуулах хороонд Радио өргөн нэвтрүүлгийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нэр бүхий байгууллага, ААН-ээс албан тоотоор МҮОНР-ийн 1 дүгээр программыг 21 аймгийн төвд 76-90 МГц-ийн давтамжаар дахин дамжуулах радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг олгох хүсэлтийг 2025 оны 6 дугаар сард ирүүлсэн болно. Энэхүү ирүүлсэн санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт” болон Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”, тус тогтоолд нэмэлт оруулсан 2023 оны 88 тоот тогтоол, баримт бичгийн хүрээнд тус хорооны РДЗХГ, ЗУХАГ, Хуулийн хэлтэс хамтран судалж, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг боловсруулан сонгон шалгаруулалт зарлахаар санал боловсруулсан болно. Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанд холбогдох бүтцийн нэгжүүд хамтран Сонгон шалгаруулалт зарлах тухай (Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт) танилцуулга, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төсөл, баримт бичгийн төслийн агуулга, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хугацааны хуваарийн төслийн дэлгэрэнгүй

танилцуулга, тооцоо судалгаа, тогтоолын төслийг хэлэлцүүлэв. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 150 тоот “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” тогтоолыг баталсан. Энэхүү тогтоолд, “Нэг. Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр зарлаж, “Сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Хоёр. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээний ажлын хэсэг байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.гэжээ. ХХЗХ-ноос уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **ХХЗХ-2025 /ОНДД-СШ-01/** тоот “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрөөс 60 хоногийн хугацаатай зарласан болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалтыг үндэслэн баталсан зохицуулах хорооны 2025 оны ээлжит 12 дугаар хуралдааны /2025-05-29/ 115 тоот тогтоолоор ХХЗХ-ноос 2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог баталсан юм. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тус хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанд ӨНЗГ, ЗЗҮТЗГ, ЗУХАГ, Хуулийн хэлтэс хамтран “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” багц 5 сонгон шалгаруулалтын баримт бичгийн төсөл, баримт бичгийн төслийн агуулга, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хугацааны хуваарийн төсөл, дэлгэрэнгүй танилцуулга, зах зээлийн судалгаа, холбогдох танилцуулга, хууль эрх зүйн үндэслэл, тооцоо судалгаа, тогтоолын төслийг тус тус боловсруулан хэлэлцүүлэв. Үүнд:

1. Монгол Улсад арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай:
2. Улаанбаатар хотод арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай:
3. Увс аймагт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай:
4. Дундговь, Говьсүмбэр аймагт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай:
5. Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай зэрэг болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” багц 5 сонгон шалгаруулалтын асуудлыг хэлэлцээд, тус хуралдааны 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” дараах 5 тоот тогтоолыг батлан шийдвэрлсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 151 тоот “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, “Нэг. Монгол Улсын нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Хоёр. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэжээ.
- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 152 тоот “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, “Нэг.Улаанбаатар хотод Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Хоёр.Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэжээ.
- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 153 тоот “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, “Нэг.Увс аймгийн нутаг дэвсгэрт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Хоёр.Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэжээ.
- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн тус хуралдаанаар 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 154 тоот “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, “Нэг. Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Хоёр.Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэжээ.

- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.2, 5¹.1.11 дэх заалт, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 155 тоот “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, Нэг. Орон нутагт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл болон “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Хоёр. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэжээ.

Хорооны 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн дээр заасан 151, 152, 153, 154, 155 тоот тогтоолууд батлагдсантай холбогдуулан тогтоолыг хэрэгжүүлэх, эдгээр нээлттэй сонгон шалгаруулалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрөөс 60 хоногийн хугацаагаар зохион байгуулах, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ӨНЗГ /Э.Золбаяр/, ЗУХАГ /З.Эрдэнэчулуун/-т тус тус даалгав.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 8 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 8 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 156 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрлийг (Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 157 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрлийг (Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 158 тоот тогтоолыг баталж, тогтоолоор Онлайн нетворк ХХК-д Монгол Улсын нутаг дэвсгэрт “Мэдээллийн сүлжээ ашиглах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь

заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 159 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар (Коожицү монголиа ХХК, 43200177 тоот: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс–Япон Улс/) 5 жилийн хугацаагаар сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.1, 1.3 дах заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12.1 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 160 тоот тогтоолыг баталж, тогтоолоор Тамсаг мэнэнгийн тал ХХК-ийн Дорнод аймгийн нутаг дэвсгэрт “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” 13000173 тоот тусгай зөвшөөрлийг 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 30 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээ байгуулах, ашиглах журам”-ын 4.3.2, 5.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 161 тоот тогтоолыг баталж, тогтоолоор Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээний суурин ярианы үйлчилгээнд зориулан 26хх-хххх дугаарлалт бүхий нэг сая сүлжээний дугаарыг 5 жилийн хугацаагаар Тагнуулын ерөнхий газарт шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 162 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг (Коллпро ХХК: 1800-2555) 2 жилийн хугацаатай сунган тус тус шийдвэрлэв.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 “харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичиг, журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;” дах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр 2012 оноос эхлэн тоног төхөөрөмжийг баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Баталгаажуулах үйл ажиллагааг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор Үндэсний итгэмжлэлийн төвөөс MNS ISO / IEC 17065:2013 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага” стандартын шаардлагыг хангаж буйгаа нотлон 2014 оноос эхлэн тус хорооны Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар нь энэ стандартаар итгэмжлүүлэн харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмжийг баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэхүү стандартыг итгэмжлүүлэх шаардлагад тухайн стандартыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг баримтжуулах зорилгоор “Чанарын гарын авлага” баримт бичгийг боловсруулж, батлуулан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг болно. ХХЗХ-ны Даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/39 дугаар тушаалаар Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын бүтцийн нэгжид өөрчлөлт оруулж, тоног төхөөрөмжийн баталгаажуулалттай үйл ажиллагааг “Баталгаажуулалтын хэлтэс” хэрэгжүүлж эхлээд байна. ХХЗХ-ны тоног төхөөрөмжийг баталгаажуулах үйл ажиллагааны MNS ISO / IEC 17065:2013 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага” стандартын итгэмжлэлийн PC 04 дугаартай гэрчилгээний хугацаа 2025 оны 05 дугаар сард сунгуулах хүсэлтийг хүргүүлсний хүрээнд Үндэсний итгэмжлэлийн

төвөөс 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 17-ны өдрүүдэд магадлах шалгалт хийгдсэн бөгөөд 4 үл тохирол байна гэж дүгнэсэн, эдгээр үл тохирлын нэг нь баталгаажуулалтын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй “Чанарын гарын авлага”-д тус Хорооны баталгаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтцэд өөрчлөлт оруулсан талаар тусгаж, баримтжуулах шаардлагатай болсон. Иймээс Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар ХХЗХ-ны РДЗХГ, ЗУХАГ, Хуулийн хэлтэс хамтран уг үл тохирлыг нийцүүлэн залруулахтай холбоотойгоор Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн “Баталгаажуулалтын үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлах тухай” 43 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтаар батлагдсан “Чанарын гарын авлага”-ын 5.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах үндэслэл танилцуулга, зөвлөмжийн залруулга, 2019 оны 43 тоот тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 163 тоот “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг батлав. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, “Нэг.Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн “Баталгаажуулалтын үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлах тухай” 43 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтаар батлагдсан “Чанарын гарын авлага”-ын 5.1 дэх хэсгийг дараах байдлаар өөрчилсүгэй. Үүнд: “5.1 Харилцаа холбооны зохицуулах хорооны бүтэц. Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлд Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийг тодорхойлсон бөгөөд Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийг баталж, үүгээр зохицуулах хорооны зохион байгуулалтын бүтцийг тодорхойлж өгсөн. Харилцаа холбооны зохицуулах хороо нь ажлын албатай байх бөгөөд Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар нь радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, шинэ техник, технологийн судалгаа хийх, ашиглах радио давтамжийн зурвасын нөөцийг бүрдүүлэх, радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах зөвшөөрөл, харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, тохирлын гэрчилгээ олгох, үндэсний радио давтамж хуваарилалтын нэгдсэн бүртгэлийг хөтлөх, олон улсын радио давтамжийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, үндэсний радио долгион хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийж дүгнэлт гаргах чиг үүргийг хариуцан ажилладаг. Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар нь Зохицуулах хорооны харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хариуцсан нэгж бөгөөд тус газрын дарга нь ажлаа Зохицуулах хорооны даргад тайлагнаж хариуцлага хүлээнэ. Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын үйл ажиллагааны чиглэлээс хамаарч тоног төхөөрөмжийг баталгаажуулах үйл ажиллагааг Баталгаажуулалтын хэлтэст, радио давтамжийн зохицуулалттай холбоотой үйл ажиллагааг Радио давтамжийн зохицуулалтын хэлтэс, радио долгион хяналттай холбоотой үйл ажиллагааг Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв тус тус хариуцан ажиллаж байна. Тус хорооны баталгаажуулалтын үйл ажиллагааны удирдлага нь дараах чиг үүргийг тус тус хариуцан, хэрэгжүүлнэ. Үүнд: -Хорооны дарга тохирлын гэрчилгээ олгох, сунгах, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэр гаргах, тохирлын гэрчилгээ, гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах; -РДЗХГ-ын дарга баталгаажуулалтын үйл ажиллагаатай холбоотой тохирлын үнэлгээний шийдвэрийг хянах, баталгаажуулах; - Баталгаажуулалтын хэлтсийн дарга нь тохирлын үнэлгээний дүгнэлт, үнэлгээнд хяналт тавих, бусад тохирлын үнэлгээтэй холбоотой үйл ажиллагааг зохион

байгуулах.”. 2 дугаар заалтад, Хоёр. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. “гэжээ. Тус хуралдаанаар хорооны 2025 оны 163 тоот тогтоол батлагдсантай холбогдуулан 2025 оны ээлжит 15 дугаар хуралдааны үеэр асуудлыг хэлэлцэх үеэр нэр бүхий зарим гишүүдээс гаргасан санал зөвлөмжийн дагуу харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын бүтэц зохион байгуулалт, удирдлага тогтолцоо, үйл ажиллагааг шинэчилсэн хууль, тогтоомж болон Үндэсний итгэмжлэлийн төвөөс 2025 оны 06 дугаар сард өгсөн тохирлын үнэлгээний дүгнэлт бүх үл тохирлыг залруулан нийцүүлэх, баталгаажуулалтын арга хэмжээг БНХАУ-ын зээлийн төслийн хэрэгжилттэй уялдуулах, цаашид баталгаажуулалтын үйл ажиллагааны талаар тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлүүлэх, холбогдох гарын авлага, дүрэм журам, үнэ тариф, процесс нөхцөл шаардлагыг боловсронгуй болгох арга хэмжээний санал, дүгнэлтийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөө гарган ажиллаж, 2025 оны сүүлийн хагас жилдээ багтаагаад Хорооны хуралдаанд хэлэлцүүлэх, шийдвэрлүүлэхийг тус хуралдааны тэмдэглэлээр РДЗХГ /Ц.Чулуунбат/-т үүрэг болгохоор тогтов. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд тогтоолыг албажуулан (2025-07-09, 03/1453) Үндэсний итгэмжлэлийн төв-д хүргүүлсэн болно.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <https://crc.gov.mn/documents/xxzx-togtool> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-07-19